



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2023.02.20. № 37.

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ГАНЧИМЭГ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос өссөн нь 179,283.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал болон үндсэн хөрөнгийг хүлээн авч, тайлагнасантай холбоотой бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2022 оны Б/33 дугаар захирамжаар төсөв захирагч нарт балансын урамшуулал олгох тухай, А/333 дугаар захирамжаар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баярын үйл ажиллагааг зохион байгуулахад идэвх, санаачилгатай ажилласан албан хаагчдыг урамшуулах тухай шийдвэрүүдийг гаргасан нь удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

0012021175

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 13 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 71 арга хэмжээг хэрэгжүүлэн, Луус сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2023/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дундговь аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70593113

Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын орлон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахым хаяг: dundgovt@audit.gov.mn

Ауд. н. 20. № 57.

Тайлбар: _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б. ГАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос өссөн нь 179,283.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал болон үндсэн хөрөнгийг хүлээн авч, тайлагнасангай холбоотой бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2022 оны Б/33 дугаар захирамжаар төсөв захирагч нарт балансын урамшуулал олгох тухай, А/333 дугаар захирамжаар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баярын үйл ажиллагааг зохион байгуулахад идэвх, санаачилгатай ажилласан албан хаагчдыг урамшуулах тухай шийдвэрүүдийг гаргасан нь удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

0012021175

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 13 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 71 арга хэмжээг хэрэгжүүлэн, Луус сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,878,078.14	139,109,099.14
33	АВЛАГА	1,296,720.00	-
335	Бусад авлага	1,296,720.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,011,600.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	285,120.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	40,581,358.14	50,709,099.14
351	Түүхий эд материал	8,972,751.00	12,767,092.00
35110	Тусгай зориулалттай материал	8,972,751.00	12,767,092.00
354	Хангамжийн материал	31,608,607.14	37,942,007.14
35410	Бичиг хэргийн материал	300,000.00	591,000.00
35420	Аж ахуйн материал	30,288,007.14	32,147,407.14
35450	Барилгын засварын материал	-	4,183,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,020,600.00	1,020,600.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	88,400,000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	88,400,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	904,961,335.14	1,002,653,832.13
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	904,961,335.14	1,002,653,832.13
392	Биет хөрөнгө	836,623,335.14	872,199,832.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	987,380,686.20	1,089,382,123.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(257,965,278.30)	(320,744,969.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,167,630.00	75,672,830.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,223,141.17)	(53,218,274.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,934,663.00	82,183,403.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,991,871.02)	(55,527,612.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,632,508.00	54,029,540.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,482,862.53)	(39,266,207.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,447,900.00	55,447,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,276,899.04)	(15,758,900.40)
393	Биет бус хөрөнгө	68,338,000.00	130,454,000.00
39301	Програм хангамж	2,735,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,735,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	68,338,000.00	130,454,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	946,839,413.28	1,141,762,931.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	60,600.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60,600.00	-
413	Өглөг	60,600.00	-
4136	Бусад өглөг	60,600.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	60,600.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	946,778,813.28	1,141,762,931.27
51	Засгийн газрын хувь оролцоо	946,778,813.28	1,141,762,931.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	467,471,147.29	467,471,147.29
51101	Өмч: - төрийн	467,471,147.29	467,471,147.29
512	Хуримтлагдсан үр дүн	69,220,811.63	264,204,929.62
51210	Өмнөх үеийн үр дүн	69,220,811.63	69,220,811.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	194,984,117.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	410,086,854.36	410,086,854.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	946,839,413.28	1,141,762,931.27

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	510,050,618.00	688,322,641.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,017,780.60	291,220,772.43
120	Нийтлэг татварын бус орлого	79,017,780.60	291,220,772.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,017,780.60	291,220,772.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	773,177.00	2,998,335.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,244,603.60	288,222,437.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	431,032,837.40	397,101,868.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,933,537.40	39,720,968.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,640,000.00	850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,520,917.91	24,828,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,772,619.49	14,042,668.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	352,099,300.00	357,380,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,099,300.00	357,380,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	602,527,139.31	490,536,423.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,527,139.31	490,536,423.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561,830,289.21	428,540,805.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,130,203.00	189,536,402.00
210101	Үндсэн цалин	137,405,703.00	156,697,922.00
210102	Нэмэгдэл	26,551,100.00	23,282,186.00
210104	Урамшуулал	13,173,400.00	9,556,294.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,655,963.00	23,772,495.00
210201	Тэтгэврийн даатгал	14,783,000.00	15,232,929.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,978,600.00	3,000,632.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,582,800.00	1,532,450.23
210204	Ажилгүйдлийн даатгал	395,700.00	359,092.34
210205	Эрүүл мэндийн даатгал	3,915,863.00	3,647,390.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,940,474.00	26,029,755.00
210301	Гэрэл, цахилгаан	2,414,655.00	3,461,365.00
210302	Түлш, халаалт	20,525,819.00	22,568,390.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,683,566.76	25,120,112.00
210401	Бичиг хэрэг	7,405,100.00	3,982,800.00
210402	Тээвэр, шатахуун	14,936,045.30	11,678,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,863,460.00	2,610,727.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	3,370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,405,528.86	3,478,480.00
210408	Бараа материал акталсны зардал	4,473,508.31	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	819,924.29	-
2105	Нормативт зардал	5,898,998.60	50,220.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,999,940.00	50,220.00
210502	Хоол, хүнс	779,058.60	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,120,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,850,645.00	6,450,000.00
210604	Урсгал засвар	29,850,645.00	6,450,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,210,000.00	3,208,000.00
210702	Дотоод албан томилолт	2,210,000.00	3,208,000.00

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,735,061.00	19,138,903.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,721,417.00	17,711,295.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,800.00	198,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,176.00	174,776.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	221,668.00	639,032.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,725,377.85	135,234,918.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,451,923.80	26,163,078.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,614,000.00	1,294,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,659,454.05	107,777,840.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,696,850.10	61,995,618.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,990,590.00	19,682,090.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,370,600.00	15,148,690.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,619,990.00	2,533,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,706,260.10	42,313,528.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,706,260.10	42,313,528.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(92,476,521.31)	197,786,217.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,319,720.00	2,802,099.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,802,099.43
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,319,720.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(10,319,720.00)	(2,802,099.43)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(102,796,241.31)	194,984,117.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	430,509,294.40	401,396,924.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	488,057.00	3,283,455.20
120	Нийтлэг татварын бус орлого	488,057.00	3,283,455.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	488,057.00	3,283,455.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	488,057.00	3,283,455.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	430,021,237.40	398,113,468.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,921,937.40	40,732,568.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,640,000.00	850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,520,917.91	24,828,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,761,019.49	15,054,268.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	352,099,300.00	357,380,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,099,300.00	357,380,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	398,546,474.40	384,916,924.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,546,474.40	384,916,924.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,849,624.30	322,921,306.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,130,203.00	189,536,402.00
210101	Үндсэн цалин	137,405,703.00	156,697,922.00

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	26,551,100.00	23,282,186.00
210104	Урамшуулал	13,173,400.00	9,556,294.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,655,963.00	23,772,495.00
210201	Тэтгэврийн даатгал	14,783,000.00	15,232,929.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,978,600.00	3,000,632.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,582,800.00	1,532,450.23
210204	Ажилгүйдлийн даатгал	395,700.00	359,092.34
210205	Эрүүл мэндийн даатгал	3,915,863.00	3,647,390.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,786,474.00	26,029,755.00
210301	Гэрэл, цахилгаан	2,414,655.00	3,461,365.00
210302	Түлш, халаалт	20,371,819.00	22,568,390.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,125,869.30	25,922,927.00
210401	Бичиг хэрэг	4,662,700.00	4,273,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,452,479.30	11,677,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	463,460.00	2,612,527.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	3,370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,767,230.00	3,989,100.00
2105	Нормативт зардал	7,473,960.00	200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,999,940.00	-
210502	Хоол, хүнс	674,020.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,800,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,433,945.00	10,633,000.00
210604	Урсгал засвар	26,433,945.00	10,633,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,210,000.00	3,208,000.00
210702	Дотоод албан томилолт	2,210,000.00	3,208,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,674,461.00	19,983,808.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,660,817.00	18,556,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,800.00	198,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,176.00	174,776.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	221,668.00	639,032.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,358,749.00	23,634,919.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,744,749.00	22,220,919.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,614,000.00	1,414,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,696,850.10	61,995,618.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,990,590.00	19,682,090.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,370,600.00	15,148,690.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,619,990.00	2,533,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,706,260.10	42,313,528.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,706,260.10	42,313,528.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,962,820.00</u>	<u>16,480,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,962,820.00	16,480,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,962,820.00	16,480,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,962,820.00	16,480,000.00
223001	Бусад хөрөнгө	10,319,720.00	8,030,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,643,100.00	8,450,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(31,962,820.00)</u>	<u>(16,480,000.00)</u>

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,471,147.29	410,086,854.36	172,017,052.94	1,049,575,054.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,471,147.29	410,086,854.36	172,017,052.94	1,049,575,054.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(102,796,241.31)	(102,796,241.31)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,471,147.29	410,086,854.36	69,220,811.63	946,778,813.28
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,471,147.29	410,086,854.36	69,220,811.63	946,778,813.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,471,147.29	410,086,854.36	69,220,811.63	946,778,813.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	194,984,117.99	194,984,117.99
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,471,147.29	410,086,854.36	264,204,929.62	1,141,762,931.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357,380,900.00	324,491,545.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	321,380,900.00	313,491,545.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,677,600.00	293,809,455.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,799,000.00	189,536,402.00

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	157,629,200.00	156,697,922.00
210102	Нэмэгдэл	25,436,600.00	23,282,186.00
210104	Урамшуулал	11,733,200.00	9,556,294.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,392,700.00	23,772,495.00
210201	Тэтгэврийн даатгал	15,689,100.00	15,232,929.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,005,100.00	3,000,632.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,574,900.00	1,532,450.23
210204	Ажилгүйдлийн даатгал	374,300.00	359,092.34
210205	Эрүүл мэндийн даатгал	3,749,300.00	3,647,390.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,028,100.00	24,458,504.00
210301	Гэрэл, цахилгаан	2,700,000.00	1,890,114.00
210302	Түлш, халаалт	23,228,100.00	22,568,390.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,852,900.00	20,664,227.00
210401	Бичиг хэрэг	4,160,100.00	4,160,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,652,500.00	6,652,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,603,700.00	2,492,527.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,394,200.00	3,370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,042,400.00	3,989,100.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	5,500,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,382,000.00	3,208,000.00
210702	Дотоод албан томилолт	3,382,000.00	3,208,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,355,900.00	4,354,908.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,927,300.00	2,927,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,800.00	198,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,800.00	174,776.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	640,000.00	639,032.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,167,000.00	22,114,919.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,753,000.00	20,700,919.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,414,000.00	1,414,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,703,300.00	19,682,090.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,703,300.00	19,682,090.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,153,300.00	15,148,690.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	2,533,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,000,000.00	11,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,000,000.00	11,000,000.00
223001	Бусад хөрөнгө	36,000,000.00	11,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357,380,900.00	324,491,545.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,380,900.00	321,208,089.80
122005	Орон нутгийн төсвөөс	357,380,900.00	321,208,089.80
120010		-	3,283,455.20
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,591,851.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,591,851.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,591,851.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,571,251.00
210301	Гэрэл, цахилгаан	1,571,251.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,280,000.00
210401	Бичиг хэрэг	135,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,025,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,133,000.00
210604	Урсгал засвар	5,133,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,607,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,607,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,140,717.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,140,717.80
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,140,717.80
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	6,140,717.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,732,568.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,732,568.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,828,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,054,268.80
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж тасралтгүй сурталчлах алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус онд байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд шинэчлэн байгууллагын даргын тушаалаар батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 194,923.5 мянган төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	1,296.7	-	(1,296.7)
Бараа материал	40,581.4	139,109.1	98,527.7
Үндсэн хөрөнгө	904,961.3	1,002,653.8	97,692.5
Нийт хөрөнгө	946,839.4	1,141,762.9	194,923.5
Өр төлбөр	60.6	-	(60.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	946,778.8	1,141,762.9	194,984.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	946,839.4	1,141,762.9	194,923.5

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансанд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г нөөцийн бараагаар орлого авч тайлагнасангай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд тайлант онд 178,272.4 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 18,739.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталжээ. Үндсэн хөрөнгийн дансны материаллаг өөрчлөлтөөс тодруулбал сумын ОНХС-гийн хөрөнгөөр төмөр сүргийг 30,000.0 мянга, 8 айлын 2 орон сууцанд 79,915.9 мянган төгрөгийн их засвар хийж, сайжруулалтаар тайлагнажээ.

Дээрх үндсэн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй орлого авсантай холбоотой тайлант оны үр дүн өсжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 359,271.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 9,101.1 мянган төгрөгөөр бууруулан, 350,170.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 43 дугаар тогтоолоор өглөг барагдуулах зорилгоор 7,210.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 357,380.9 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 357,380.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 357,380.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 3,283.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, 321,208.1 мянган төгрөгийг зарцуулан 36,172.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 321,208.1 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажиллаж цалинг, хогийн машин худалдан авахаар тендер зарласан ААНБ, иргэд тендерт оролцоогүй учраас бусад хөрөнгө тус тус зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

80101 ¹	192,127.3	186,264.3	5,863.0	96.9
80106 ²	33,595.4	33,414.2	181.2	99.5
80112 ³	51,991.7	50,192.1	1,799.6	96.5
80714 ⁴	2,000.0	2,000.0	-	100.0
80801 ⁵	3,500.0	3,495.4	4.6	99.9
80802 ⁶	2,550.0	2,533.4	16.6	99.3
80815 ⁷	11,653.3	11,653.3	-	100.0
80918 ⁸	36,000.0	11,000.0	25,000.0	30.6
81102 ⁹	16,680.0	16,679.9	0.1	100.0
82212 ¹⁰	3,394.2	3,370.0	24.2	99.3
82801 ¹¹	3,889.0	3,889.0	-	100.0
70106 ¹²	357,380.9	324,491.6	32,889.3	90.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 24,828.3 мянга, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 850.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,054.3 мянга, нийт 40,732.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,571.3 мянга, хангамж, бараа материалын зардалд 5,280.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 5,133.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 20,607.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,000.0 мянга, нийт 34,591.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл 6,140.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

¹ Үндсэн үйл ажиллагааны зардал

² Баг хорооны үйл ажиллагааны зардал

³ Нийтлэг үйлчилгээ

⁴ Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт

⁵ Нөхөн олговор

⁶ Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг

⁷ Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор

⁸ Бусад

⁹ Орон нутгийн нөөц хөрөнгө

¹⁰ Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ

¹¹ Улсын их баяр наадам

¹² Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын захирал, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 3/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардал 491,610.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,916.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 29 арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой бүл ажиллагааны зардал 121,136.9 мянган төгрөг буурсны дийлэнх хувь нь хангамж, бараа материал, эд, хогшил урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардлын бууралт байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалтуудыг зөрчин 832.9 мянган төгрөгийг зарцуулсан зөрчлийг илрүүлж, төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 онд нийт 375,627.9 мянган төгрөгийн 52 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулжээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн, хариут Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хийхээр шийдвэрлэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31,074.0 мянган төгрөгийн алдаа¹³ илрүүлснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. ОНХС-аар бэлтгэсэн 30,000.0 мянган төгрөгийн төмөр сүргийг бараа материалын дансанд бүртгэсэн.;

¹³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2. Бараа материалын үлдэгдэлд биетээр байгаа 1,074.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд зардалд тайлагнасан.

Аудитаар нийт 832.9 мянган төгрөгийн зөрчил¹⁴ илэрснээс 832.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 заалт албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр 832.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т /Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно/, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/ заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоог зөрүүтэй бодож баталгаажуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т /Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ОНХС-аар бэлтгэсэн төмөр сүргийг бараа материалын	1	30,000.0			1	30,000.0	1	30,000.0				

¹⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

дансанд бүртгэсэн;													
Бараа материалын үлдэгдэлд биетээр байгаа хөрөнгийг шууд зардалд тайлагнасан.	1	1,074.0			1	1,074.0	1	1,074.0					
Дүн	2	31,074.0			2	31,074.0	2	31,074.0					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгосон.	1	832.9	1	832.9									
Хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоог зөрүүтэй бодож баталгаажуулсан.	1	-			1	-							
Дүн	2	832.9	1	832.9	1	-							